



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 86

Есөнбулаг сум

Төсөл сонгон шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг давсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д заасан шаардлагыг хангасан хавсралтад дурдсан төслүүдэд хөнгөлөлттэй зээл олгохоор тогтсугай.

2. Шалгарсан төслүүдэд хөнгөлөлттэй зээл олгох гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллан, үр дүнг жил бүрийн эцэст тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.


ДАРГА

Т.ГАНЗОРИГ



0200386

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 04-ний
өдрийн 8 тогтоолын хавсралт



“АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ
БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ”-ЫН ДАГУУ
ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛЭНД ХАМРАГДАХ ТӨСЛҮҮД

№	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Төслийн нэр	Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, тоо	Олгох зээлийн хэмжээ
1	Удмын Ундраа ХХК	Есөнбулаг сумын иргэн, ААНБ-ыг дулаанаар хангах	31 иргэн, 2 ААН, 3 төсвийн байгууллагыг дулаанаар хангах	50.0 сая
2	Галуутын хишиг хоршоо	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Сав баглаа боодолтой сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 30 хувийг хангах	30.0 сая
3	Эконобэ индрасти ХХК	Эко шахмал түлшний үйлдвэр байгуулах	Жилд 5400 тн шахмал түлш үйлдвэрлэнэ.	40.0 сая
4	Ханлиг Тайшир ХХК	3D Кино театр	108 хүний суудалтай кино театр байгуулж, 162000 хүнд үйлчлэх	40.0 сая
5	Могойн бор ХХК	Махны чиглэлийн үхэр үржүүлж, мах бэлтгэх үйлдвэр барих	35 тугалтай үнээ, 1 бух худалдан авч өсгөх, тэжээлийн ургамал тариалах	40.0 сая
Дүн				200.0 сая